ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/89/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: Gansukh.audit@gmail.com

Аудитор: Р.Цэрэндолгор

Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр хот

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. Аудитын тайлан ........ 9
3.1 Ерөнхий зүйл ........ 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
3.4 Материаллаг байдал ........ 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 11
3.8 Аудитын гол асуудал ........ 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 12
4. Аудитын илрүүлэлт ........ 12
4.1 Залруулсан алдаа ........ 12
4.2 Төлбөрийн акт ........ 12
4.3 Албан шаардлага ........ 13
4.4 Зөвлөмж ........ 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 13


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.00 № 122
танай ____________-ны №____________-т

ДЭЛХИЙН ӨВ-ОРХОНЫ ХӨНДИЙН
СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Л.ОТГОНБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас нийт 12,714.9 мянган төгрөгөөр компьютер техник хэрэгсэл худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалт; 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 0.00 | 2,409,013.80 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.00 | (0.00) |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | (0.00) |
| 3121 | Төгрөг | 0.00 | (0.00) |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | (0.00) |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | 0.00 |
| 33 | АВЛАГА | - | 18,913.80 |
| 335 | Бусад авлага | - | 18,913.80 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 18,913.80 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | - | 2,390,100.00 |
| 354 | Хангамжийн материал | - | 2,390,100.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 132,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 2,257,600.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 21,277,570.37 | 59,486,397.87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 21,277,570.37 | 59,486,397.87 |
| 392 | Биет хөрөнгө | 21,277,570.37 | 31,162,397.87 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 42,202,700.00 | 42,202,700.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (38,762,973.97) | (41,012,973.97) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 19,390,989.75 | 34,909,189.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,310,017.52) | (11,798,715.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,133,346.00 | 12,722,687.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,834,407.18) | (9,404,407.60) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,868,000.00 | 3,868,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (410,066.71) | (773,466.73) |
| 39217 | Номын фонд | - | 449,385.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 28,324,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 324,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 28,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 21,277,570.37 | 61,895,411.67 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 21,277,570.37 | 61,895,411.67 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 21,277,570.37 | 61,895,411.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 26,173,388.50 | 26,173,388.50 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 26,173,388.50 | 26,173,388.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (4,895,818.13) | 35,722,023.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (4,895,818.13) | (4,895,818.13) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 40,617,841.30 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 21,277,570.37 | 61,895,411.67 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 314,738,833.31 | 339,042,326.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,153,333.31 | 35,166,026.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,153,333.31 | 35,166,026.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,153,333.31 | 35,166,026.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,153,333.31 | 35,166,026.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 313,585,500.00 | 303,876,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 313,585,500.00 | 301,618,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 313,585,500.00 | 301,618,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 2,257,600.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 2,257,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 320,951,472.50 | 298,424,484.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 320,951,472.50 | 298,424,484.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 296,306,790.88 | 279,815,200.92 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 214,410,532.75 | 202,399,865.20 |
| 210101 | Цалин | 153,299,088.75 | 155,780,590.20 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 61,111,444.00 | 46,619,275.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,016,817.63 | 26,681,901.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 18,630,000.00 | 18,966,224.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,166,600.00 | 2,068,500.14 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,711,146.79 | 1,668,680.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 397,568.26 | 336,844.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,111,502.58 | 3,641,651.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,209,248.00 | 6,517,349.97 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 1,209,248.00 | 517,349.97 |
| 210304 | Байрны түрээс | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,631,300.00 | 7,195,800.00 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 942,800.00 | 686,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 6,218,100.00 | 4,171,700.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 1,185,800.00 | 1,031,200.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | - | 173,300.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,284,600.00 | 1,132,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,484,000.00 | 443,400.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 1,484,000.00 | 443,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 21,442,220.00 | 22,265,786.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,179,470.00 | 22,078,586.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 262,750.00 | 187,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,112,672.50 | 14,311,098.50 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 5,078,700.00 | 4,639,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,033,972.50 | 9,672,098.50 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,644,681.62 | 18,609,283.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,820,781.00 | 800,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,820,781.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,000,000.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,823,900.62 | 17,809,283.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,823,900.62 | 17,809,283.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (6,212,639.19) | 40,617,841.30 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (6,212,639.19) | 40,617,841.30 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 26,173,388.50 | - | 1,316,821.06 | 27,490,209.56 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 26,173,388.50 | - | 1,316,821.06 | 27,490,209.56 |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | - 6,212,639.19 | - 6,212,639.19 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 26,173,388.50 | - | - 4,895,818.13 | 21,277,570.37 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 26,173,388.50 | - | - 4,895,818.13 | 21,277,570.37 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 26,173,388.50 | - | - 4,895,818.13 | 21,277,570.37 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 40,617,841.30 | 40,617,841.30 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 26,173,388.50 | - | 35,722,023.17 | 61,895,411.67 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 313,585,500.00 | 303,876,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 313,585,500.00 | 303,876,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 313,585,500.00 | 301,618,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 313,585,500.00 | 301,618,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 2,257,600.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 2,257,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 310,917,500.00 | 288,903,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 310,917,500.00 | 288,903,800.00 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 286,272,818.38 | 270,294,516.22 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 214,410,532.75 | 202,418,779.00 |
| 210101 | Үндсэн цалин | 154,387,171.75 | 155,799,504.00 |
| 210102 | Нэмэгдэл | 60,023,361.00 | 46,619,275.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,016,817.63 | 26,681,901.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 18,630,000.00 | 18,966,224.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,166,600.00 | 2,068,500.14 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,711,146.79 | 1,641,360.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 397,568.26 | 364,165.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,111,502.58 | 3,641,651.22 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 7,209,248.00 | 6,517,349.97 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 1,209,248.00 | 517,349.97 |
| 210304 | Байрны түрээс | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,631,300.00 | 7,328,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 942,800.00 | 819,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,218,100.00 | 4,171,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,185,800.00 | 1,031,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 173,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,284,600.00 | 1,132,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,484,000.00 | 443,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,484,000.00 | 443,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,442,220.00 | 22,265,786.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 20,221,620.00 | 22,078,586.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 220,600.00 | 187,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,078,700.00 | 4,639,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 5,078,700.00 | 4,639,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,644,681.62 | 18,609,283.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,820,781.00 | 800,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,820,781.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,000,000.00 | 800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,823,900.62 | 17,809,283.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,823,900.62 | 17,809,283.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,668,000.00 | 14,972,500.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,668,000.00 | 14,972,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,668,000.00 | 14,972,500.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,668,000.00 | 14,972,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,668,000.00 | 14,972,500.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (2,668,000.00) | (14,972,500.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | (0.00) | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | | Тайлант он | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 314,585,500.00 | 310,761,599.38 | 301,618,700.00 | 283,809,416.22 | 94.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 314,585,500.00 | 310,761,599.38 | 301,618,700.00 | 283,809,416.22 | 94.10 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 291,768,700.00 | 288,940,818.38 | 300,818,700.00 | 283,009,416.22 | 94.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 216,660,100.00 | 214,410,532.75 | 216,660,100.00 | 202,806,114.00 | 93.61 |
| 210101 | Үндсэн цалин | 155,352,100.00 | 154,387,171.75 | 166,320,000.00 | 156,186,839.00 | 93.91 |
| 210102 | Нэмэгдэл | 61,308,000.00 | 60,023,361.00 | 50,340,100.00 | 46,619,275.00 | 92.61 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,296,400.00 | 27,016,817.63 | 29,249,100.00 | 26,294,566.25 | 89.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,630,000.00 | 18,630,000.00 | 20,582,700.00 | 18,578,889.64 | 90.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,166,600.00 | 2,166,600.00 | 2,166,600.00 | 2,068,500.14 | 95.47 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 1,733,300.00 | 1,711,146.79 | 1,733,300.00 | 1,641,360.14 | 94.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433,300.00 | 397,568.26 | 433,300.00 | 364,165.11 | 84.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,333,200.00 | 4,111,502.58 | 4,333,200.00 | 3,641,651.22 | 84.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,500,000.00 | 7,209,248.00 | 6,517,400.00 | 6,517,349.97 | 100.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 1,500,000.00 | 1,209,248.00 | 517,400.00 | 517,349.97 | 99.99 |
| 210304 | Байрны түрээс | 6,000,000.00 | 6,000,000.00 | 6,000,000.00 | 6,000,000.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,631,300.00 | 9,631,300.00 | 7,328,300.00 | 7,328,300.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 942,800.00 | 942,800.00 | 819,400.00 | 819,400.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 6,218,100.00 | 6,218,100.00 | 4,171,700.00 | 4,171,700.00 | 100.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,185,800.00 | 1,185,800.00 | 1,031,200.00 | 1,031,200.00 | 100.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,284,600.00 | 1,284,600.00 | 173,300.00 | 173,300.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,488,000.00 | 1,484,000.00 | 1,132,700.00 | 1,132,700.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,488,000.00 | 1,484,000.00 | 444,100.00 | 443,400.00 | 99.84 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,114,200.00 | 24,110,220.00 | 444,100.00 | 443,400.00 | 99.84 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 22,893,600.00 | 22,889,620.00 | 35,980,700.00 | 34,980,686.00 | 97.22 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,000,000.00 | 1,000,000.00 | 34,793,500.00 | 34,793,486.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 220,600.00 | 220,600.00 | 1,000,000.00 | - | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 5,078,700.00 | 5,078,700.00 | 187,200.00 | 187,200.00 | 100.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,078,700.00 | 5,078,700.00 | 4,639,000.00 | 4,639,000.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,816,800.00 | 21,820,781.00 | 4,639,000.00 | 4,639,000.00 | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,816,800.00 | 21,820,781.00 | 800,000.00 | 800,000.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,816,800.00 | 20,820,781.00 | 800,000.00 | 800,000.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | 800,000.00 | 800,000.00 | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 314,585,500.00 | 313,585,500.00 | 301,618,700.00 | 301,618,700.00 | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 314,585,500.00 | 313,585,500.00 | 301,618,700.00 | 301,618,700.00 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 314,585,500.00 | 313,585,500.00 | 301,618,700.00 | 301,618,700.00 | 100.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) | - | (0.00) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 18.00 | 18.00 | 18.00 | 18.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | 13.00 | 13.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 | 4.00 | 4.00 | 100.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - | - |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,257,600.00 | 2,257,600.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 18.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.07-ны өдрийн 01/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг сурталчлан алдаршуулах, хадгалан хамгаалах, шинжлэн судлах, соёлын бүтээлч

үйлдвэрлэл, тогтвортой хөгжлийн орчин бий болгож хойч үедээ өвлүүлэх үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх зорилго тавьсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газар нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 298.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 12.7 сая төгрөгөөр суурин компьютер, 0.2 сая төгрөгөөр ширээ, сандал худалдан авсан. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 301.618 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 4.1 хувиар буурсан байна. Энэ нь бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолтын зардал буурсантай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 301.6 сая төгрөгөөр санхүүжигдэн, 301.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтээр нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас 2.3 сая төгрөг зарцуулсан байна. .

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас нийт 12.7 сая төгрөгөөр компьютер техник хэрэгсэл худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 171 мэдээлэл байршуулснаас 30 мэдээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалт; 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд санхүүжилтийг сар бүр мэдээлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 12.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй хөрөнгө бусад биет бус хөрөнгө 28.0 сая төгрөгийн газрыг зөв ангиллаар авч залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

**4.3 Албан шаардлага**

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас нийт 12,714.9 мянган төгрөгөөр компьютер техник хэрэгсэл худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

2. Шилэн дансны цахим хуудаст 171 мэдээлэл байршуулснаас 30 мэдээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

*2.1. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

*Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа | 2 | 12.7 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 12.7 | 1 | 00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ө.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Р.ЦЭРЭНДОЛГОР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НЫ ӨДӨР